

## 1. Геологийн хэсэг

### 1.1. Ордын районы физик-газарзүйн нөхцөл.

«Найрамдал» тоосгоны шаврын орд нь Улаанбаатар хотын баруун хойт хэсэгт Сонгино хайрхан дүүргийн нутагт, Толгойтын зүүн салааны амны эхэнд оршино.

Газар зүйн байршлын хувьд орд нь Хэнтийн салбар уулсын нэг Толгойтын нурууны өмнөт үзүүрт, 1370-1420 м-ийн харьцангуй өндөршилтэд оршино. /Хавсралт зураг №1/

Орд нь нийслэл хотын нутаг дэвсгэрт орших тул уур амьсгалын хувьд хотын уур амьсгалтай нэг адил бөгөөд жилийн хамгийн хүйтэн хугацаа нь 1-2-р сарууд бөгөөд эдгээр саруудад агаарын температур нь -28,1 градус С хүрэх ба зарим тохиолдолд хааяа-35 градус С, хамгийн дулаан нь 7-р сард +17-25 градус С заримдаа +30 градус С хүрнэ. Хөрсний хөлдөлтийн гүн нь дунджаар 3-4 м-т хэлбэлзэнэ.

Усан сүлжээний хувьд ордын район нь Туул гол түүний цутгалуудаас бүрдэх ба ордын районд хамгийн ойр нь Туул голын баруун цутгал болох Баруун салаа гол юм.

Энэ районд ихэнхдээ баруун, баруун хойноос чиглэлтэй салхи салхилах бөгөөд салхины хурд нь гол төлөв 1-5 м/сек орчим байна. Жилд дундажаар 242,7 мм хур тунадас унадаг.

Ордын талбай нь ургамал амьтнаар тун ядуувтар бөгөөд нийт талбайн хэмжээнд уулын нугын ургамал голлох боловч ургамлын бүрхэвч нь суурин газрын нөлөөний улмаас талхлагдаж, хомстол бий болон сийрэгжсэн.

### 1.2. Ордын районы геологийн судалгааны түүх

Улаанбаатар хот түүний орчмын нутгийн геологийн судлалгааг 20-р зууны эхэн үеэс эхтэй гэж үзэж болох боловч тухайн үеийн судалгаа нь зөвхөн маршрут-ажиглалтын чанартай байсан бөгөөд 1925 оноос ЗХУ-ын Шинжлэх ухааны академи ба БНМАУ-ын Шинжлэх ухааны хорооны хамтарсан экспедицүүд байгуулагдан үйл ажиллагаа явуулж эхэлсэнийг геологийн судалгааны жинхэнэ эхлэл гэж үздэг.

1930 онд БНМАУ-ын засгийн газрын хүсэлтээр ЗХУ-ын ШУА-ийн ажилтан З.А.Лебедев Улаанбаатар хот түүний орчмын талбайд 1:1000000 ны масштабтай геологийн зураглал хийжээ.

Энэ зураглалын ажлын гол зорилго нь Улаанбаатар хот орчимд барилгын материалын түүхий эдүүдийн орд, илрэлүүдийг олж тогтооход оршиж байв.

Энэ судалгааны хүрээнд нийслэл хотын бүтээн байгуулалттай холбогдуулан тухайн үедээ гол шаардлагатай байсан барилгын материал, нүүрс гэх мэт зарим төрлийн ашигт малтмалын эрэл хайгуулын ажлууд нилээд эрчимтэй явагдаж байснаар Улаанбаатар хот орчмын геологи ашигт малтмалын тухай мэдээллийг тодорхой хэмжээгээр арвижуулсан байна.

В.В.Деньлов, Н.Е.Невзаров нар 1940 онд 1:100000-ны масштабын геологийн зураглалын ажлыг Улаанбаатар хотын түүний баруун хойд хэсгээр хийж, элсжин ба хөрсөн чулууны тунамал бүрдлийг анх ялган дунд эрт төрмөлийн насанд хамааруулжээ.

Энэ ажлын дүнд Улаанбаатар хот болон түүний орчмын талбайд тоосгоны шаврын 14 орд, элсний 3 орд илрүүлсэн байна..

Энэ ажлын дүнд Баруун салаа голын зүүн эрэгт орших Толгойтын тоосгоны шаврын орд (одоогийн Найрамдал орд), Хужир булангийн тоосгоны шаврын ордуудыг илрүүлж хэтийн төлөвтэй гэж үнэлжээ.

### 1.3. Ордын районы геологийн тогтоц

Ордын хучаас хурдас нь элювиаль, хажуугийн (делювиаль), хажуу-хормойн (делювиаль-пролювиаль) хурдсуудаас тогтоно.

Ордод доод цэрдийн настай хурдас тархсан бөгөөд энэ хурдас нь дээд, дунд ба доод 3 давхрагаас бүрдэнэ. Эдгээрээс ордын ашигт малтмалд дээд ба доод давхрагын шаварлаг хурдас хамаарна

“Найрамдал” ордын цэрдийн настай хурдас нь зүүн ургаш 120-130<sup>0</sup> –ын азимутаар 8-13<sup>0</sup>-ын өнцгөөр унасан ба палеозойн хурдас чулуулагтай стратиграфын үл нийцлэгээр хиллэсэн байна.

Дээд давхрагын шаврын зузаан нь 2009 онд хайгуул хийсэн хэсэгт 5,0-46,0 м-т хэлбэлзэж байна.

Уг шавар нь цайвар саарал, ногоовтор саарал, ногоовтор-бор өнгөтэй шаврын давхрагаас бүрдэх бөгөөд цайвар саарал өнгөтэй шавар нь маш нягт, бага зэрэг аргиллит маягийн болсон нимгэн хуудаслаг тогтоцтой ба шаврын давхрага нь дотроо жижгэвтэр хайргатай элсэнцэрийн нарийн судланцаруудыг агуулсан байна.

Дээд давхрагын шавар нь дотроо 9,6-19,1% /дунджаар 14,6%/ жижиг ба дунд зэргийн ширхэгтэй хайрганцар агуулах ба шаврын уян хатаны тоо нь 10,7-19,2 /дунджаар 15,3/ байна.

Доод давхрагын шаврын зузаан нь 2009 онд хайгуул хийсэн хэсэгт 15,0-30,0 м байх ба эдгээр нь зарим газартаа жижиг хайргатай конгломератын жижиг мэшил агуулсан байна.

Энэ хурдас нь цайвар саарал, шаравтар саарал, ногоовтор саарал шавар ба ногоовтор бор өнгөтэй аргиллит маягийн шаврын давхрагаас бүрдэнэ.

Доод давхрагын шавар нь дотроо 1,4-18,2% /дунджаар 16,2%/ жижиг ба дунд зэргийн ширхэгтэй хайрганцар агуулах ба шаврын уян хатаны тоо нь 15,9-17,7 /дунджаар 17,0/ байна.

## **2. Ордын ашигт малтмалын чанарын үнэлгээ, технологийн шинж чанар**

2009 онд шинээр өрөмдсөн бүх цооногуудаас дээж авч Барилга Архитектур Корпорацын Барилгын материал, технологийн судалгааны төвд физик-механикийн хураангуй шинжилгээг хийлгэсэн ба  $>0.5$ ,  $>0.063$ ,  $0.063-0.02$ ,  $0.02-0.006$ ,  $0.006-0.002$ ,  $< 0.002$ мм -ийн тороор шигшүүлж шаврын ширхэгийн бүрэлдэхүүн шаварлаг хэсэг, тоосорхог хэсэг, элсэрхэг хэсгүүд, том хэмхдэслэг хольцын агуулгыг тодорхойлуллаа.

Энэ шинжилгээгээр шавар дахь  $> 0.5$  мм-ийн хэмжээтэй хэсэг буюу том хэмхдэслэг хольц нь 10.6%-оос 32.8%-д хэлбэлзэх ба ордын хэмжээнд дунджаар 17.5% байгаа нь уг шавар нь том хэмхдэслэг хольцын хэмжээгээр их агуулгатайд хамаарагдаж байна

Иймд уг шаврыг тоосго үйлдвэрлэлд ашиглахдаа түүнийг 0.5мм-ийн тороор шигшиж ашиглах шаардлагатай юм.

Химийн шинжилгээний үр дүнгээс харахад Найрамдал ордын шавар нь  $Al_2O_3$ -ын агуулгаараа хүчиллэг шаварт,  $Fe_2O_3$ -ын агуулгаараа будагч исэл багатайд хамрагдаж байна.

Цацраг идэвхжилийн судалгаагаар ордын дээд давхрагын шаврын радиийн эквивалент нь 111,6 Бк/кг, ордын доод давхрагын шаврын радиийн эквивалент нь 108,7 Бк/кг байгаа нь барилгын материалд түүний зөвшөөрөгдөх хэмжээ 370 Бк/кг-аас 3,3-3,4 дахин бага байгаа нь түүгээр тоосго үйлдвэрлэхэд

бүрэн тохирох ба эрүүл ахуйн хувьд ямар нэг сөрөг нөлөөлөл байхгүйг нотлож байна.

Энэ нь уг ордын шавраар MNS-2513-99-ийн шаардлагыг хангасан 125-150 маркийн, эрүүл ахуйн шаардлага хангасан ердийн ба нүхтэй улаан тоосго үйлдвэрлэхэд тохирохыг харуулж байна.

### 3. Ордын геологийн тогтоц

Ордын хучаас хурдас нь элювиаль, хажуугийн (делювиаль), хажуу-хормойн (делювиаль-пролювиаль) хурдсуудаас тогтоно.

Ордод доод цэрдийн настай хурдас тархсан бөгөөд энэ хурдас нь дээд, дунд ба доод 3 давхрагаас бүрдэнэ. Эдгээрээс ордын ашигт малтмалд дээд ба доод давхрагын шаварлаг хурдас хамаарна

“Найрамдал” ордын цэрдийн настай хурдас нь зүүн ургаш 120-130° –ын азимутаар 8-13°-ын өнцгөөр унасан ба палеозойн хурдас чулуулагтай стратиграфын үл нийцлэгээр хиллэсэн байна.

### 4. Ордын гидрогеологийн нөхцөл

“Найрамдал” шаврын орд нь Улаанбаатар хот дотор орших тул гидрогеологийн нөхцлийн хувьд Улаанбаатар хоттой адил төстэй юм.

Орд орчмын талбайд газрын доорхи усны дараахь төрлүүд тохиолдоно.

1. Дөрөвдөгчийн хурдас дахь давхрагын ус
2. Гуравдагч-цэрдийн хурдас дахь давхрагын ус
3. Цэрдийн хурдас дахь давхрагын ба ан цавын ус
4. Элсэн чулуу- занар давхрага дахь ан цавын ус
5. Боржин ба бусад чулуулаг дахь ан цавын ус

1. Дөрөвдөгчийн хурдас дахь давхрагын ус нь элювийн, делювийн, делюви-пролювийн, пролювийн, аллювийн ба алюви-пролювийн хурдасны гэж ангилагдана.

Элювийн хурдас дахь давхрагын ус маш бага талбайд тохиолдоно. Делюви ба делюви-пролювийн хурдастай холбоотой ус агуулагч давхрагатай олон тооны усны эх ундрага холбоотой байдаг.

### 5. Уулын ажлын хуанличилсан төлөвлөгөө

Шаврын ил уурхай 2023 онд 03-р сарын 15-наас 11-р сарын 01-ний хооронд 8 сар ажиллана. Эхний 1 сард техник тоног төхөрөмжийн засвар үйлчилгээ, шахмал түлшний татан авалт зэрэг бэлтгэл ажил хийгдэнэ.

Уурхай жилд 42.1 мян.м<sup>3</sup> шавар олборлож 10сая ширхэг тоосго үйлдвэрлэхээр 2023 оны төлөвлөгөөндөө тусгалаа.

Уурхай улиралын горимоор жилд 130 хоног, хоногт 2 ээлж, ээлжинд 8 цагаар бүрэлдэхүүнтэй ажиллана .

Хүснэгт № 1

	3	4	5	6	II улирал	7	8	9	III улирал	10	11		IV улирал
Шавар олборлолт мян.м <sup>3</sup>	-	5	5	5	15	10	8	5	23	4.1			4.1
Тоосго гаргалт сая.ш		0.8	1	1	2.8	2.15	2.5	2	6.65	0.55			0.55

Хүснэгт №2

Ашиглалтын хаягдал	Технологийн хаягдал	Бохирдолт
%	%	м <sup>3</sup>
1.06	2	1.76

**6. Тоосгоны үйлдвэрийн технологи**

“Монгол Керамик” ХК-ийн тоосгоны үйлдвэр нь MNS-2513-99-ийн шаардлагыг хангасан 125-150 маркийн, эрүүл ахуйн шаардлага хангасан ердийн ба нүхтэй улаан тоосгыг 1997 оноос хойш үйлдвэрлэж байна.

Шаврын ордоос олборлож, баяжуулан үйлдвэрийн талбайн овоолгод нөөцөлсөн шаврыг технологийн шугамд өгч тоосго үйлдвэрлэдэг. Технологийн схемийг хавсаргав.

Тоосгоны үйлдвэрлэлт технологийн үндсэн 4 дамжлагаас бүрддэг. Үүнд :

1. Шавар боловсруулалт
2. Тоосго хэвлэх
3. Тоосго хатаах
4. Тоосго шатаах

1. Шавар боловсруулалт:

Баяжуулах цехээс ирсэн цэвэр шаврыг тоосгоны шаврын санд хүлээн авах ба уг санд нөөцөлсөн шавраас Т-170 бульдозероор түрж цагт 30-40 м<sup>3</sup> – ийн хүчин чадалтай ТCIW15 маркийн хайрцагт тэжээгүүрт оруулж нарийн хэмжээгээр хуваарилж ВС маркийн туузан дамжуулагчаар дамжуулан GS1000x800 маркийн өндөр хурдаар бутлах бутлуурт өгнө. Уг бутлуур нь бутлан ангилж цэвэр шаврыг анхан шатны SJJ300x40 маркийн хоёр голт зуурагчид дамжуулах ба энэ нь усаар чийглэн зуурч 2 дахь шатны хоёр голт зуурагч руу шилжүүлнэ. 2 дахь шатны хоёр голт зуурагч нь нийт хэрэглэгдэх усны 90%-ийг өгч зуурах ба үүнийг өндөр хурдтай булт бутлуураар дахин буталж үйлдвэрийн технологийн шаардлагад бүрэн нийцсэн зуурмагийг бэлэн болгоно.

2 Тоосго хэвлэлт:


Уг зуурмагийг JKB 50/50 вакумтай хэвлэх машинаар 3,8 mPa даралттай шахаж, агааргүйжүүлэн 18-20%-ийн чийглэгтэй сайн нягтаршсан гулдмайг гарган авна.Энэхүү гулдмайг зүсэж хэрчин хагас бэлэн бүтээгдэхүүн /түүхий тоосго/-ийг бэлдэнэ. Хагас бэлэн бүтээгдэхүүнийг өнгө үзэмж, хэлбэр хэмжээг сайн болгохын тулд хэрчэгчийн өмнө өндөр үр дүнтэй нэмэгдэл төхөөрөмж муштукийг суурилуулж өгнө.

3. Тоосго хатаалт:


Хагас бэлэн бүтээгдэхүүн /түүхий тоосго/-ийг хатаахдаа хонгил хатаагуураар хатаах ба үүнд дугуй зуухнаас гарсан халуун агаарыг ашиглана. Энэ арга нь эдийн засгийн хувьд хэмнэлттэйгээс гадна үр дүн сайтай байдаг.

Хонгилт хатаагуурт түүхий тоосгыг тусгай тэргэнцэрт ачих ба нарийн графикайн дагуу цагаар түлхэж оруулна. Хатаах зуухны дулааны горимыг тусгай төхөөрөмжийн тусламжтайгаар өндөр хянан системтэй удирдана.

Технологийн схем



### 14. Тоосго хэвлэх цех



- |                                |                                      |                               |
|--------------------------------|--------------------------------------|-------------------------------|
| 1. Хайрлагч тэжээгүүр          | 11. Головдон буцах туузан дамжуулагч | 19. Холчигч автоматтай бункер |
| 2. Туузан дамжуулагч           | 12. Холчигч бункер                   | 20. Хуваарилгыг автомат       |
| 3. Булт булгуур                | 13. Туузан дамжуулагч                | 21. Сул тэрэг татах машин     |
| 4. Туузан дамжуулагч           | 14. Алхан булгуур                    | 22. Тэргэнгэр                 |
| 5. Хоёр гонг зуурагч           | 15. Туузан дамжуулагч                | 23. Цахилгаан тэрэг           |
| 6. Туузан дамжуулагч           | 16. Конус нийлгүүр                   | 24. Сул тэргэний зам          |
| 7. Хэвжиг машин                | 17. Головдон буцах туузан дамжуулагч |                               |
| 8. Вакум насос                 | 18. Туузан дамжуулагч                |                               |
| 9. Хэрчигч автомат             |                                      |                               |
| 10. Авагчийн туузан дамжуулагч |                                      |                               |

#### 4. Тоосго шатаалт:

Хатсан тоосгыг 36 амтай 2 ширхэг дугуй шатаах зууханд оруулах ба үүнд тусгай

зөөгч машиныг ашиглан тээвэрлэн зуухандаа өрнө. Бүрэн өрсний дараа хатаалт, хөргөлт, шатаалт гэсэн 3 бүсд галаа оруулна. Галлаж эхэлсэний дараа шатааж дууссан тоосгоо гаргаад хатсан тоосгыг тасралтгүй өрж явуулна. Нэг баюу тоосго өрсний дараа хаалт хийж өгнө. Нунтаг нүүрсээ галлагааныхаа нүхээр хийнэ. Ердийн хайламтгай шавартай учраас 870-900<sup>0</sup> температурт шатаалт явагдаж дуусна.

#### 6. Дэд бүтэц

Ордын талбайд олборлоход шаардлагатай тоног төхөөрөмж, хүнд механизм хүргэх, машин техник явахад ямар нэг хүндрэлгүй, чөлөөтэй нэвтрэх боломжтой. Орд нь дэд бүтэц, зам харилцаа сайн хөгжсөн, зах зээлдээ ойрхон, бүтээгдэхүүнээ шуурхай хүргэх боломжтой зэрэг таатай нөхцөлтэй юм.

Тус уурхайн ажиллагсад нь Улаанбаатар хотод амьдардаг учир ажиллагсдын тосгоныг тусгай газар барих шаардлагагүй юм.

Орд нь Улаанбаатар хотод Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт тоосгоны үйлдвэрээс 1,5 км зайтай орших ба тэдгээрийг холбосон авто замыг сайжруулан зассан тул түүхий эдийг автомашинаар тээвэрлэх боломжтой юм.

#### Цахилгаан хангамж

Үйлдвэрлэлийн болон ахуйн цахилгааны хэрэглээг Улаанбаатар хотын “Сонгинохайрхан цахилгаан түгээх сүлжээ” ХК-ийн харьяа 35.0 Кв-ын дэд станцаас хангах ба 6/1000 кВа чадалтай 0.4 Кв-ын трансформатор байна.

Уурхай нь дулааны улиралд 8 цагийн үргэлжлэлтэй 2 ээлжээр ажиллана. Уурхай болон үйлдвэрийн цахилгааны гол хэрэглэгчид нь үйлдвэрлэлийн барилга байгууламж, тоног төхөөрөмж, уурын зуух, баяжуулах цех, харуул хамгаалалтын байр, цайны газар, үйлдвэрийн гэрэлтүүлэг зэрэг болно.

#### Усан хангамж

“Монгол керамик” ХК нь 2005 онд өрөмдөж гаргасан 26 м гүнтэй 4,2 л/сек ундрага бүхий өөрийн гүний худагтай.

Энэ худаг нь үйлдвэрээсээ 1,2 км-т орших ба үйлдвэрийн болон ахуйн бусад хэрэгцээний усыг эндээс хангадаг.

#### 7. Шаврын карьерт хийгдэх нөхөн сэргээлтийн ажил

Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиудад зааснаар төсөл хэрэгжүүлэгч аливаа байгууллага төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, гадаадын ба олон улсын байгууллага гадаад, дотоодын иргэн, харьяалалгүй хүмүүс нь төслийн хэрэгжилтийн явц, үр дүнг хянах, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, байгаль орчныг хамгаалах зорилгоор байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөртэй ажиллана. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, түүнийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байна.

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт үйлдвэрлэлийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж буй өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга, хэлбэр, хугацааг тодорхойлсон байна.

“Монгол керамик ” ХК нь өөрийн гүний худагтай, карьер болон үйлдвэрийн хоорондох замаа хайрган хучилттай замаар хучсан. Салхи тос шороо ихтэй өдрүүдэд өөрийн усны машинаар зам талбайгаа усалдаг. Усны машин нь зориулалтын усалдаг төхөөрөмжтэй болно. Үйлдвэрийн техник

технологи нь бүрэн автомажсан. Тус компани нь “Найрамдал” ордоо ашиглаж дуусаад уурхайлсан талбайгаа тэгшилж, барилга барих төлөвлөгөөтэй байгаа.

### **7.1. Нөхөн сэргээлтийн ажилд баримтлах стандартууд**

“Монгол керамик” ХК нь нөхөн сэргээлтийн ажлыг хэрэгжүүлэхдээ “Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томъёо, тодорхойлолт MNS5914:2008” стандартыг голчлон баримтлана. “Уул, уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаар эвдэрсэн газрын ангилал” MNS 5915:2008, “Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрсний хуулалт, хадгалалт” MNS 5916:2008 гэх мэт стандартуудыг мөрдөж ажиллана.

### **8. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

2023 онд Тэр бум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд үйлдвэрийн ойролцоо 200ш ширхэг мод бутыг 0,2 га талбайд тарина.

### **9. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Төслийн үйл ажиллагаатай холбоотой нүүлгэн шилжүүлэх ажил хийгдэхгүй болно.

### **10. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Төслийн үйл ажиллагаатай холбоотой түүх соёлын өвийг хамгаалах ажил хийгдэхгүй болно.

## **11. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ, ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР**

### **Сөрөг нөлөөлөл**

Энэхүү төсөл хэрэгжсэнээр байгаль орчинд дараахь сөрөг нөлөөлөл үзүүлнэ.

Үүнд:

- Олборлолтын үеэр тодорхой хэмжээний газрын гадарга өөрчлөгдөж, хөрсөн бүрхэвч, ургамалан нөмрөг устана.
- Олборлолтын үед агаарт тоос шороо дэгдэн, машин механизмын утаа орчны агаарыг бохирдуулна.
- Газрын доорхи усны нөөцөд нөлөөлж, ус бохирдож болзошгүй.
- Төслийн талбай орчмын хөрсний биологи, химийн шинж чанарт өөрчлөлт орж, машин механизмийн хөдөлгөөнөөр хөрс эвдрэлд орно.
- Шатахуун, тос тослох материал, техникийн хог хаягдал ба ахуйн хаягдлаар хөрс бохирдоно.
- Тодорхой хэмжээний бэлчээрийн талбайн ургамлын бүрхэвч устгах буюу талхлагдах ба хөрс тээвэрлэлтийн үед тоос шороо нь орчмын ургамлын бүрхэвчид сөрөг нөлөөлөл учруулна.
- Ан амьтны амьдрах орчинд сөрөг нөлөөлөл үзүүлнэ.

### **Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө**

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажлын хүрээнд тодорхойлсон төслөөс байгаль орчин нийгэм, хүний эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөллийг тодорхойлж, нөлөөллийг бууруулах чиглэлээр хийх ажлуудыг сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөнд харуулав.



**Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ**

Хүснэгт №3

№	Арга хэмжээ	Эхлэх хугацаа	Давтамж
<b>А. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ</b>			
1	Машин механизмын хөдөлгүүрийн тохиргоо, үйлчилгээг тогтмолжуулах, хөдөлгүүрээс гарах утааны хэмжээг стандартын шаардлага хангах хэмжээнд байлгах	2023	Үйл ажиллагааны туршид
2	Түлш шатахууны чанар, техникийн ажиллагаанд хяналт тавих	2023	Үйл ажиллагааны туршид
3	Орчинд тоосжилт ихсэхээс хамгаалж, зам усалгааны машин ажиллуулах, төлөвлөгөөний дагуу зам услах	2023	Үйл ажиллагааны туршид
4	Орон нутаг болон орчны хөрсний талхлалт, тоос шороо үүсэхээс сэргийлж тогтсон журам, тэмдэг тэмдэглэгээ тавих	2023	Үйл ажиллагааны туршид
5	Уурхайн гадуурх талбайд автомашин явахад мөрдөх хурдны хэмжээг тогтоож, мөрдүүлэх	2023	Үйл ажиллагаа эхлэхийн өмнө
6	Тоосжилтийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх, дээж авах байршлыг салхины чиглэлийн дээд, доод талд байрлуулах, салхины хурдны нөлөөгөөр тоосжилт нэмэгдэх боломж нөхцлийг хязгаарлах.		Хяналт шинжилгээ хийх үед
7	Ахуйн хаягдалыг тусгайлан бэлтгэсэн битүү хаалттай саванд ангилан хийж, хаягдалын нэгдсэн цэгээс хуурай хөнгөн хаягдал хийсэхгүй байх, нарийн ширхэгтэй тоос шороо үүсгэхгүй байх нөхцлийг хангаж, MNS 5344:2003 стандартын дагуу тээвэрлэх, ангилах, түүнд хяналт тавиж ажиллах	2023	Тухай бүрт нь
<b>Б. Усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ</b>			
1	Жил бүр батлагдсан хөтөлбөрийн дагуу байгаль орчны хяналт шинжилгээний ажлыг гүйцэтгэж, усны бохирдлыг хянаж шинжилгээ өгнө.	2023	Жил бүр
2	Байгаль орчны менежментийн төлөвлөлтийн арга хэмжээ, үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан удирдлагын зохион байгуулалтыг бий болгох	2023	Ашиглалтын үйл ажиллагаа эхлэхээс өмнө
3	Усны менежментийн зохистой үйл ажиллагааг явуулж, хэрэгжүүлэх, болзошгүй эрдслийг бууруулах талаар ажилчдад заавар зөвлөгөө өгөх	2023	Жил бүр
4	Монгол улсын БОНХЯ наас баталсан дүрэм журманд нийцүүлэн хэрэглээний усыг ашиглах	2023	Үйл ажиллагааны туршид
5	Ахуйн бохир усыг ус, хөрс бохирдуулахгүй цооногт хуримтлуулан ариун цэврийн байгууллагаас тогтоосон цэгт зайлуулж байх,	2023	Тогтмол

- **Ажил олгогч нь:** Ажилтныг хөдөлмөрийн аятай нөхцөл бүхий ажлын байраар хангах бөгөөд үйлдвэрийн явцад бий болсон хими , физик , биологийн хүчин зүйл нь ажлын байргны хөдөлмөрийн эрүүл ахуй, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх нөхцлийг бүрдүүлнэ. Ажил олгогч нь хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилдаг ажилтанд хамгаалах хэрэгсэл , ажлын тусгай хувцас , хор саармагжуулах бодис, хоол хүнсний бүтээгдэхүүн зэргийг олгоно. Ажил олгогч нь ажилтныг эрх бүхий байгууллагаас баталсан журмын дагуу үйлдвэрлэл,

ажил үйлчилгээний холбоотой зайлшгүй шаардлагатай эрүүл мэндийн урьдчилсан ба хугацаат үзлэгт оруулна.

- Аюулгүй ажиллагаа: Уурхайн бүх ажил үйлдлүүд “ Ил уурхайн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийн дагуу явагдана.

\* Уурхайн хажуу догол , дотоод ба гадаад овоолгуудын тогтворжилтыг хамгаалсан байна.

\* Үйлдвэрийн осол гэмтэлтэй тэмцэх

\* Ил уурхайн агаарын хэт хуурай шимт , тоосжилттой тэмцэх

\* Уурхайд тогтсон усыг цаг хугацаанд нь зайлуулах

\* Уурхайн ажлын бус хажуу болон овоолгын гулсалт, нуралтаас болгоомжилж тогтворжилтыг шалгаж хянаж байх

\*Уурхайн цас бороо, үерийн хамгаалах усны шуудуу ус орж ирэх боломжтой бүх талаас нь татан хамгаалсан байх зэрэг аргуудыг нарийн мэргэжлийн дагуу хийсэн байна.

Хүснэгт №4

№	Ажлын нэр	Хэнд	Хариуцах эзэн	Хугацаа
1	Уурхайн үйл ажиллагаа эхлэхээс өмнө төсөл хэрэгжих талбайн өнөөгийн байдлыг танилцуулах	Төсөл хэрэгжих талбай орчмын нутгийн иргэд, холбогдох хүмүүс	Уурхайн дарга, Байгаль орчны мэргэжилтэн	V сард
2	Нийт хийгдсэн ажлуудын хэмжээ, хийгдсэн ажлуудын тайлагнал	Төсөл хэрэгжих талбай орчмын нутгийн иргэд, сумын байцаагч орчны байцаагч,холбогдох хүмүүс	,Байгаль орчны мэргэжилтэн	X сард

\* Үйлдвэрийн ажиллагаа явуулах явцад “Техникийн аюулгүй ажиллагааны дүрэм” –ийг хатуу мөрдөж хүн бүрийг ТАА-ны дүрэмтэй танилцуулж сургалтанд хамруулсан байна.

\* ТАА-ны ажиллагааны дүрэмд заасны дагуу ажиллаж байгаа өрөм, цахилгаан тоног төхөөрөмжийг нурлын призмийн гандан талд доголын ирмэгээс 3 м-ээс багагүй зайд нүүрэн талаарааа доголын ирмэгт хөндлөн байрлуулсан байх.

\* Автомашин болон тээврийн бусад хэрэгсэл овоолго дээр чуллуулгийн гулсах зурвасын дагуу гулсах хүрээний гадан зогсож ачаагаа буулгах ба гулсах зурвасын өргөнийг маркшейдерийн хэмжилтээр тогтоон ажилчдад мэдээлж байна.

\* Уулын ажлыг уурхайн ашиглалтын мэргэжлийн хүний удирдлагын доор явуулна.

\* Үйлдвэрийн ослоос урьдчилан сэргийлэх аюулгүй ажиллагааны талаар ажилчдад тогтмол зааварчилгаа өгч байна.

\* Удирдлагаас үйлдвэрийн бүх ажиллагаанд аюулгүй ажиллагааны дүрмийг мөрдөж байгаа талд хатуу хяналт тогтмол тавьж ажиллана.

**- Үйлдвэрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагаа**

\* Үйлдвэрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагаанд аюулгүй ажиллагааны дүрмийг мөрдөж байгаа талд хатуу хяналт тогтмол тавьж ажиллана. буулгах ба гулсах зурвасын өргөнийг маркшейдерийн хэмжилтээр тогтоон ажилчдад мэдээлж байна. ийг бүрдүүлнэ. Ажил олгогоч нь хөвчилсан үнэлгээнд дурьдсан зөвлөмжүүдийг туйлын нарийн чанд сахин биелүүлбэл дээрхи бэрхшээлүүдийг гэтлэн давах юм.

Ил олборлолтыг явуулахад тухайн орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг арилгах, аюулгүй ажиллагааны байдлыг хангахын тулд байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний дүн , сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх , түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмж, уурхайн

олборлолтын үйл ажиллагааг явуулах техник технологийн дүрэм журам, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг мөрдлөг болгон ажиллах цаг хугацаанд нь хэрэгжүүлсэн тохиолдолд тус уурхайг ажиллуулах боломжтой.

### **Хөрсөн бүрхэвчийн эвдрэл доройтол**

Хөрсөн бүрхэвчийн эвдрэл доройтолын үндсэн шалтгаан нь уурхайн карьер, хөрс хуулах, овоолгууд, туслах байгууламж зам харгуй зэрэг болно. Иймд маркшейдерийн хэмжилтээр малталтын хил хязгаарыг тэмдэгжүүлж, технологийн ажиллагааг явуулан, ашиглалт дууссан хэсэгт нөхөн сэргээлт хийн “Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага” стандартын дагуу ургамалжуулан хөрсжүүлэх, олборлолтыг дотоод овоолготой явуулах, хаягдалуудыг карьерийн хоосон орон зай, эсвэл байгалийн гуу, жалга, зэрэг гадаргыг оновчтой ашиглан аюулгүй нөхцөлийг хангах хэлбэр хэмжээтэй байршуулах машин механизмын засварын болон уурхайд ажиллагсадын орон байр, үйлчилгээний газрыг эмх цэгцтэй байрлуулж орчны бохирдолыг байнга цэвэрлэж байна.

Карьерын болон бусад замыг тэмдэгжүүлэн олон зам гаргахаас сэргийлж, үндсэн замаа байнга засаж шаардлагатай хэсэгт хаалт, хамгаалалт хийнэ.

Уурхайн болон бусад эдэлыэр газрын хэмжээг үнэн зөв оновчтой байрлалтай.

### **Байгаль орчныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд мөрдлөг болгон ажиллах стандарт, норм норматив**

#### **Агаар орчны бохирдолт**

Нөлөөлөл - Агаар (Хөрс хуулалт, шавар олборлолт, тээвэрлэлт, хөрсний овоолго)

Нөлөөлөлд өртөх объект - Уурхайн ойр орчимд байгаа хүн, амьтан, тоосны төвд орших уурхайн ажилчид, амьтан, ургамал

Стандарт, нормоор зөвшөөрөгдөх хэмжээ, байгаль орчны зөвшөөрөл гэрчилгээгээр зөвшөөрөгдөх хэмжээ

Орчны агаарт байх тоос болон хорт хийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ

Ажиглалт хяналт явуулах шаардлага

- ◆ Ашиглалтын хугацаанд мэргэжлийн байгууллагаар агаарын сорьц, дээж авахуулан шинжилгээ хийлгэж зөвлөгөө авч байх
- ◆ Ашиглалтын хугацаанд ажилчдын эрүүл мэндийг мэргэжлийн эмч нарт үзүүлж мэргэжлээс шалтгаалах өвчнүүдийг эмчийн хяналтанд авах

#### **Усны бохирдлоос сэргийлэх**

Нөлөөлөл – Ус (Баяжуулахад хэрэглэж буй угаалгын бохир усны сан, үерийн усны хамгаалалтын суваг шуудуу, далан, машин техникийн шатах тослох материал, унд ахуйн усны хэрэглээ)

Нөлөөлөлд өртөх объект - Газар доорх ус, малын бэлчээр, шимт хөрс бүхий газар, амьтан, мал, ургамал, ажиллагсад

Стандарт нормоор зөвшөөрөх хэмжээ

- Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томъёоны тодорхойлолт  
MNS 5914 : 2008
  - Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал  
MNS 5915 : 2008
  - Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт  
MNS 5916 : 2008
  - Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн шаардлага  
MNS 5917 : 2008
- ◆ Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага

MNS 5917 : 2008

- ◆ БОХ. Усан мандал. Газар доорх усыг бохирдлоос хамгаалах ерөнхий шаардлага MNS 3342-82
- ◆ Усны нөөцийг бохирдлоос хамгаалах дүрэм (БО, ЭМНХ-ын сайдын 1997 оны 143/А/352 тоот хамтарсан тушаалын 1-р хавсралт)
- ◆ Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт MNS 900-2005
- ◆ Унд ахуйн ус ашиглалтын зориулалттай усны объектод байх хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ (БО-ны сайд, ЭМНХ-ын сайдын 1997 оны 143/а/352 тоот тушаалын 5-р хавсралт)
- ◆ Усан орчны чанарын үзүүлэлт MNS 4586-98
- ◆ Хүн амын унд ахуйн усны эх үүсвэрийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийн дэглэм (БО, ДБХ, ЭМ-ийн сайдын 1995 оны 167/335/а/171 тоот хамтарсан тушаалын 1-р хавсралт)
- ◆ Усны нөөцийн бохирдолт, хомсдолт, нөхөн сэргээлтийг бүртгэх журам (БО сайдын 1995 оны 167/335/а/171 тоот хамтарсан тушаалын 2-р хавсралт)
- ◆ Ус хэрэглээний норм
- ◆ “Төлбөрийн хувь, хэмжээг тогтоох тухай” Засгийн газрын 7-р тогтоол, 2005 он
- ◆ Ордын ашиглалтын төсөвт байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт шинжилгээ хийлгэх зардлыг жил бүр тусган хэрэгжүүлэх ба түүнд бүх шатны төр, засгийн эрх бүхий байгууллагууд хяналт тавина.

Ажиглалт, хяналт шинжилгээ явуулах шаардлага

Ус ашиглалтын тайлан бүртгэлийг сумын тамгын газарт жил бүр гаргаж өгөх, усны найрлага, чанар, бохирдлын шинжилгээ хийлгэх

Хөрсний бохирдол, элэгдэл, эвдрэл.

Нөлөөлөл – Хөрс ( Хөрс хуулалт, тээвэрлэлт, элс, хөрсний овоолго, баяжуулалт, шатахууны хадгалалт, уурхайн суурин, байгууламж)

Нөлөөлөлд өртөх объект - Малын бэлчээр, шимт хөрс бүхий газар, амьтан, мал, ургамал

Стандарт нормоор зөвшөөрөх хэмжээ

- ◆ Ашигт малтмал эрж хайх явцад эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн шаардлага MNS 5915:2008
- ◆ Алтны шороон ордыг ил уурхайгар ашиглах явцад эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн шаардлага MNS 5917: 2008
- ◆ Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсийг хуулах техникийн шаардлага MNS 5916:2008
- ◆ Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага MNS 5918: 2008
- ◆ Эвдэрсэн газарт хучилт хийх хөрс MNS 4919: 2000
- ◆ Эвдэрсэн газрын хажуугийн налуу. Техникийн шаардлага MNS 4920: 2000
- ◆ Ашигт малтмалыг эрж хайх ажлын явцад эвдэрсэн газрыг нөхөн сэргээж ургамалжуулах заавар (БО-ны болон ХААҮ-ийн сайдын 2000 оны 64/А/62 тоот тушаалын 3 дугаар хавсралт)

**Байгаль орчныг хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардал**

Хүснэгт №5

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Зардал, мян. төг	Хариуцах эзэн
<b>А. Сөрөг нөлөөлийг бууруулах арга хэмжээний зардал</b>				
<b>1. Хөрсний бохирдлыг бууруулах арга хэмжээний зардал</b>				
1	Хатуу хог хаягдлыг эмх цэгцтэй хадгалж зохих журам, нарийвчилсан үнэлгээний зөвлөмжид заасны дагуу зайлуулах арга хэмжээ авах.	2023	200.0	Компанийн захиргаа
2	Машин техникийн үйлчилгээ, засварыг тусгай бэлтгэсэн талбайд явуулж хэвших, шатах тослох материал алдаж асгахгүй байх.	2023	-	"--"
3	Хаягдал тос, тосолгооны материалыг түр хадгалан дахин ашиглагч аж ахуйн нэгж байгууллагад нийлүүлэх, хадгалалт, хамгаалалтад анхаарах	2023	200.0	"--"
<b>Нийт</b>			<b>400.0</b>	
<b>Б. Удирдлага-зохион байгуулалтын болон бусад арга хэмжээ</b>				
Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Зардал, мян. төг	Хариуцах эзэн
1	Байгаль орчныг хамгаалах, ариун цэвэр, эрүүл ахуй, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны чиглэлээр сургалтыг өөрийн ажиллагсдын дунд зохион байгуулах.	2023	200.0	Компанийн захиргаа
2	Болзошгүй аюул ослын үед харьяа эмнэлэг бусад байгууллагатай хамтран ажиллах. Эрүүл мэндийг хамгаалах зардалд нэг хүнд	2023	600.0	"--"
<b>Нийт</b>			<b>800,0</b>	

**Хүснэгт №6 .Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө**

Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг, мян.төг	Нийт зардал, сая төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
<b>Байгалийн гамшигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр</b>								
Цаг агаарын гэнэтийн үзэгдлээс үйлдвэрлэлийн үйл ажиллагаа доголдох, зогсох	Цаг агаарын улирлын, сарын, 7 хоногийн, өдөр тутмын урьдчилсан мэдээнүүдийг төслийн үйл ажиллагаанд тогтмол ашиглах	УБ хот СХД	Өдөр	-		Цаг уурын станцтай тохиролцох	2023 он жил бүр	Ус цаг уур, орчны хяналт Шинжилгээний тухай хууль, 15-р зүйл MNS 4585:2007
Гал түймрийн улмаас үйлдвэрлэлийн үйл ажиллагаа доголдох, зогсох	Гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа, болзошгүй аюулын үед авах арга хэмжээг төслийн нийт ажилтан албан хаагчдад тогтмол хугацаанд танилцуулах Гал түймэртэй тэмцэх багаж хэрэгсэл, галын хор зэргийг тогтсон стандартын дагуу байрлуулж бэлэн байдлыг хангаж ажиллах	“Монгол”ХКкерамик					2023 он жил бүр	Галын аюулгүй байдлын тухай хууль, 16-р зүйл, MNS 5566:2005 MNS 0640:89 MNS 639:89
Газар хөдлөлт, чичирхийллийн улмаас үйлдвэрлэлийн үйл ажиллагаа доголдох, зогсох	Болзошгүй ослын үед авах арга хэмжээг төслийн нийт ажилтан албан хаагчдад тогтмол хугацаанд танилцуулах	“Монгол”ХКкерамик	-	-	-	-	2023 он жил бүр	Гамшгаас хамгаалах тухай, 27-р зүйл
<b>Үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр</b>								
Үйлдвэрлэлийн гэнэтийн ослын улмаас хүний	Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрэм журмыг сахиулж, хэрэгжилтэд хяналт тавих	“Монгол”ХКкерамик	Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах				2023 он	MNS 4990:2000

Найрамдал шаврын ордын 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

эрүүл мэнд, амь насанд сөргөөр нөлөөлж үйлдвэрлэлийн үйл ажиллагаа доголдох, зогсох,	Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны сургалтыг тогтмол хугацаанд гүйцэтгэх					MNS 4969:2000
	Ажиллагсдын хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангах	“Монгол”ХКкерамик	Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах	2023 он /Жил бүр/	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль 15-р зүйл	
	Үйлдвэрийн тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдалд тогтмол хяналт тавьж, засвар үйлчилгээг тогтмол хийж байх					
<b>Эрсдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ</b>						
Хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх эрсдэл	Салхи ихтэй, тоосжилт үүсэх улиралд тоосжилтыг бууруулах арга хэмжээг тогтмол авах	“Монгол”ХКкерамик	-	Хяналт шинжилгээний зардалд багтсан	2023 он	MNS5885:2008 MNS6148:2010 MNS4943:2015
	Орчны бүрэлдэхүүн хэсгүүдийн шинжилгээ үр дүнг магадлан итгэмжлэгдсэн хөндлөнгийн лабораториор баталгаажуулах					
	Шимт хөрсний овоолгын бүрэн бүтэн байдалд хяналт тавьж байх.	Хөрсний ажиглалтын цэгүүд	Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах			
<b>Төслийн болзошгүй эрсдлийг бууруулах чиглэлээр хийгдэх ажлын нэг жилийн нийт зардал, сая.төг</b>						-

**Хүснэгт №7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө**

Гол болзошгүй серег нөлөө	Серег нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
<b>Хог хаягдлын менежментийн чиглэлээр</b>								
Хөрс, ус, агаарын бохирдол үүсгэх	Хог хаягдлыг тогтоосон журмын дагуу ангилж, дахин ашиглах зайлуулах арга хэмжээнүүдийг тодорхойлох	Төслийн талбай	Хүн/өдөр				2023 жил бүр	Хог хаягдлын тухай хууль 9-р зүйл
	Хог хаягдлыг нэг цэгт цуглуулан ангилж, битүү саванд хадгалан тогтмол хугацаанд тээвэрлэж байх	Төсөл хэрэгжих орчин	тн	2.0	100.0	200,0/нэг жилд/		MNS 5850:2008 MNS ISO11074-1:2001
	Хөрсийг тос тосолгооны материалаар бохирдуулахыг хориглох, тосоор бохирдсон хөрсийг эрүүлжүүлсэний дараа хуулсан хөрс чулуулгийн овоолгод шилжүүлэх	Төслийн талбайд	Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах				2023 он Жил бүр	Олон улсын стандартын дагуу, Засгийн газрын 2002 оны 135 дугаар тогтоолын хавсралт Аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, Савлах, түр байршуулах, тээвэрлэх, аюулгүй болгох, хадгалах, устгах журам
	Бүх төрлийн дахин ашиглах боломжтой хог хаягдлын ангилан холбогдох байгууллагуудад тушаах	“Монгол”ХК керамик	Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах					Хог хаягдлын тухай хууль
	Техникийн засвар үйлчилгээг агуулахын нутаг дэвсгэрт хийж ажилсан тос хөрсөнд асгарах, алдагдахаас сэргийлэх	Төсөл хэрэгжих орчин	Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах					
	Дуу шуугиан ихтэй ажлын байранд ажиллагсдыг сонсголын эрхтэн хамгаалах хэрэгслээр хангах	Шуугианы түвшин өндөр хэсгүүдэд	Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах					
<b>Төслийн хог хаягдлын нөлөөллийг бууруулах чиглэлээр хийгдэх ажлын нэг жилийн нийт зардал, сая.төг</b>							<b>200,0</b>	



**Хүснэгт №8. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь**

Төсөл хэрэгжүүлэгч “Монгол керамик ” ХК нь 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг БОАЖЯаманд батлуулахаар хүргүүлж байна.

БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацаа тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
Иргэд олон нийт/дурын оролцогч, сонирхогч талууд	Санал, хүсэлт хүлээн авах төсөлтэй холбогдох гомдлын барагдуулах	Байгаль орчны талаар тавьсан санал гомдолтой холбогдол бүхий бүх төрлийн мэдээлэл	Төсөл хэрэгжих бүх хугацааны турш	Сонирхогч оролцогч талуудыг хүссэн мэдээллээр хангах	“Монгол керамик ” ХК
Байгаль орчны хяналтын улсын байцаагч	Сар бүрийн тайланг хүргүүлж санал авах	Төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлсэн ажлуудын мэдээлэл	Хагас жил тутамд	БОМТ түүний хэрэгжилт	““Монгол керамик ” ХК
БОАЖЯ	Тухайн жилийн тайланг боловсруулан хүргүүлж дараагийн жилийн төлөвлөгөөнд санал авч төлөвлөгөөг батлуулна.	Төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлсэн ажлуудын мэдээлэл	Жилийн эцэст 1 удаа		“Монгол керамик ” ХК

**УУЛ УУРХАЙН ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЯНАЛТЫН ХУУДАС**

Хянасан огноо	Шинжээч бөглөнө
Хянасан мэргэжилтэнгүүдийн хувийн дугаар	Шинжээч бөглөнө
Дүгнэлт	Шинжээч бөглөнө
1.1 Шийдвэрийн төсөл	
1.2 Ололт, амжилттай тал	
1.3 Дутагдалтай сул тал	

**НЭГ. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ХУУЛИЙН ЭТГЭЭД,  
ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ МЭДЭЭЭЛЭЛ**

1.4.1 Байгууллагын нууцын тухай хуулийн 6.1 болон 6.2-ыг үндэслэн дагуу тухайн төслийн хуулийн этгээд мэдээллийн төрлийн харгалзах мөр, багананд мэдээллийг товч хэлбэрээр үнэн зөв оруулах.

1.4.2 Тухайн төсөлд хамааралгүй мэдээллийг “*хамааралгүй*” гэж бөглөнө.

1.4.3 1.2.7 дахь хаалтын дараах зориулалт гэдэгт уурхайн хаалтын дараа нөхөн сэргээсэн газрыг бэлчээр, газар тариалан, агуулах, олон нийтэд зориулсан үйлдвэр, үйлчилгээ гэх мэт тухайн газрыг эдийн засгийн эргэлтэнд оруулахаар төлөвлөж буй бол орон нутагтай урьдчилан тохиролцсон чиглэлийг оруулах.

**НЭГ. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ХУУЛИЙН ЭТГЭЭД,  
ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ**

Хүснэгт №1

д/д	Мэдээллийн төрөл	Утга
1.1	1. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэр	“Монгол керамик” ХК
	2. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн дугаар	9010001049
	3. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэл	Барилгын материалын үйлдвэрлэл
	4. Аж ахуйн нэгжийн харъяаллын хаяг	УБ хот, СБД, 5-р хороо, Намнансүрэнгийн гудамж-5
	5. Захирлын нэр, утас, цахим шуудангийн хаяг	Э.Өлзийбаяр : Утас: 89036588, 321096
	6. Холбогдох мэргэжилтний нэр, утас, цахим шуудангийн хаяг	Уурхайн дарга С.Гончиг, утас: 91912953, Эдийн засагч Е.Нурберген 99251505
1.2	1. Төслийн нэр	“Найрамдал” уурхайн 2023 оны БО-ны менежментийн төлөвлөгөө
	2. Төслийн харъяаллын байршил	Улаанбаатар хот СХД дүүргийн нутаг
	3. Төслийн ангилал	- барилгын материал шавар ил уурхай угааж баяжуулна
	а. нүүрс, алт, жонш, төмрийн хүдэр гэх мэт	
	б. ил уурхай, далд уурхай, шороон орд	
	в. Баяжуулах	
	4. Төсөл эхэлсэн огноо	2019 оны 7-р сар
	5. Төсөл хэрэгжих хугацаа	2023он
6. Уурхайн хаалт эхлэх огноо	2033 он	
7. Хаалтын дараах зориулалт	Барилга барьж суурьшлын бүс байгуулна.	
8. ТЭЗҮ баталсан огноо	2019	

Мэдээлийг гаргасан: инженер..... / /

20..... он ..... сар..... өдөр

**ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ОЛГОГДДОГ ТУСГАЙ ЗӨВШ ӨӨРӨЛ, ДҮГНЭЛТ, ЛАВЛАГААНЫ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ**

1.5 Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай 2.3-ыг үндэслэн хуулийн хуулийн этгээд тусгай зөвшөөрөлтэй холбогдох доорх мэдээллийг үнэн зөв оруулах.

1.6 Тусгай зөвшөөрөл, үнэлгээ, дүгнэлтийг баталсан хуулийн этгээд, дугаар, огноог оруулах

1.7 Доорх хүснэгтийн 2.1.9, 2.1.10-т тусгагдсан холбогдох 7 материалын хуулбарыг байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд зайлшгүй хавсаргах. Мэдээлэл оруулах багананд хавсралтын нэрийг оруулах.

хүснэгт №2

д/д	Мэдээллийн төрөл	Утга
2.1	1. Тусгай зөвшөөрлийн төрөл /ашигт малтмал/ дугаар хүчинтэй хугацаа талбай	Ашигт малтмал ашиглах MV-00873 30 жил 31,0 гектар
	2. Тусгай зөвшөөрлийн төрөл /химийн бодис ашиглах/ дугаар хүчинтэй хугацаа	хамаарахгүй
	3. Химийн бодисын агуулгад хийсэн мэргэжлийн хяналтын газрын тодорхойлолт	хамаарахгүй
	4. Галын дүгнэлтийн огноо, дугаар	
	5. Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний огноо, баталсан хуулийн этгээд	2021 он БОАЖЯ-ны ер.шинжээч Г.Энхмөнх
	6. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний огноо, батлуулсан хуулийн этгээд	2021 он “Монслов” ХХК
	7. Ус ашиглалтын дүгнэлтийн огноо	-
	8. Тухайн жилийн уулын ажлын батлагдсан төлөвлөгөөний огноо	2023 он
	9. Батлагдсан уулын ажлын төлөвлөгөөний 1.1, 1.5, 1.7, 1.9, 1.10, 1.11 дэх маягтыг хавсаргах	
	10. ТХГН-ийн тухай хууль, Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулиар тогтоосон хамгаалалтын бүсийн хилийн заагтай давхацсан эсэхийг тодорхойлсон лавлагааг хавсаргах	
	11. Тухайн жилд баримтлах стандартын дугаар -үндэсний -олон улсын	MNS5914:2008, MNS 5915:2008, MNS 5916:2008, MNS 5917:2008, MNS 5918:2008, MNS 3298-90 MNS4048-88, MNS 0012-013-91, MNS 5080-2001 гэх мэт

**ГУРАВ. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛ, ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

1.4.4 Байгаль орчин ногоон хөгжлийн сайдын 2014 оны 01 дүгээр сарын 06-ны өдрын А-05 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын 2 дугаар хавсралтанд тусгагдсанг тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний агуулгад заагдсны дагуу химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэсгээс холбогдох доорх мэдээллийг оруулах

1.4.5 Тухайн жилд олон төрлийн химийн бодис ашиглахаар бол байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд хавсралтаар оруулж хүснэгтийн 3.1.1-д хавсралтын нэрийг дурдах /хэмжих нэгжийг дурдсан байх шаардлагатай/

1.4.6 Химийн бодисын эрсдлийн менежментийн төлөвлөгөөнд дараах мэдээллийг бүрэн тусгасан тохиолдолд 3.1.2-ын мэдээлэл оруулах хэсэгт “**хангалттай**” гэсэн дүгнэлтийг оруулна.

- 3.1 урьдчилан сэргийлэх арга хэмжээ
- 3.2 эрсдлийн үед авах арга хэмжээ
- 3.3 учруулсан хор уршгийг зайлуулах, бууруулах арга хэмжээ
- 3.4 хохирлын нөхөн төлбөрийг тооцох арга хэмжээ

1.4.7 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тухайн жилд гарах ахуйн хатуу болон шингэн хог хаягдлыг хэрхэн устгах, зайлуулах арга хэмжээ, давтамж, мониторингийн арга хэмжээг тусгах, хуванцар, резинен материал /дугуй, сав баглаа боодол/ зэрэг хог хаягдлыг дахин ашиглах цэгт хүргэх хуваарь, аюултай хог хаягдлыг хадгалах агуулах арга хэмжээг төлөвлөх шаардлагатай.

Мэдээлэл \_\_\_\_\_ үнэн \_\_\_\_\_ зөвийг \_\_\_\_\_ баталсан \_\_\_\_\_ хүний \_\_\_\_\_ гарын \_\_\_\_\_ үсэг  
 /...../ /..... он .... сар .. өдөр /

д/д	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах багана
3.1	1. Тухайн жилд ашиглах химийн бодисын нэр, хэмжээ /хэмжих нэгж/	-
	2. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	-
3.2	1. Шатах тослох материалын нэр хэмжээ /хэмжих нэгж/ агуулах байгаа эсэх	Агуулах байхгүй
	2. Тэслэх, дэлбэлэх бодисын нэр хэмжээ /хэмжих нэгж/ агуулах байгаа эсэх	

3.3.	1. Тухайн жилийн хог хаягдлын жилийн дундаж хэмжээ /хэмжих нэгж/	
	1.4.8 Ахуйн хог хаягдал /хатуу, шингэн/ 1.4.9 Үйлдвэрийн хог хаягдал /хатуу, шингэн/ 1.4.10 Аюултай хог хаягдал	Хатуу хог - 1тн Хатуу төмөр - Резин дугуй г.м Ажилласан масло, гидро шингэн - 200л
	2.Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх тухайн жилийн арга хэмжээний төсөв	200,0мян.төг

Мэдээлэл үнэн зөвийг баталсан хүний гарын үсэг  
/..... он .... сар .. өдөр /

**ДӨРӨВ. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТУХАЙН ЖИЛИЙН ТӨСӨВ**

Д/д	Хөрөнгийн зориулалт	Хэмжих нэгж	Хөрөнгийн хэмжээ мян/төг	Хугацаа
1	Сөрөг нөлөөллийг багасгах арга хэмжээ /хөрс, ус, агаар, ургамал, ан амьтан/	Мян төг	400.0	2023
2	Нөхөн сэргээлтийн зардал /биологи/	Мян төг		2023
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	Мян төг	1390,0	2023
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	Мян төг	-	2023
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	Мян төг	-	2023
6	Болзошгүй аюул, ослын менежментийн төлөвлөгөө	Мян төг	-	2023
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх тухайн жилийн арга хэмжээний төсөв	Мян төг	200,0	2023
9	Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр	Мян төг	210,0	2023
10	Удирдлага-зохион байгуулалтын болон бусад арга хэмжээ		800.0	
11	Дүн		<b>3000.0</b>	2023

Мэдээлэл үнэн зөвийг баталсан хүний гарын үсэг  
/...../

/..... он .... сар .. өдөр /

## ТАВ. МЕТА МЭДЭЭЛЭЛ

1.8 Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 39.1.7-д заасныг үндэслэн төсөл хэрэгжүүлэгчээс доорх хүснэгтэнд тусгагдсан төслийн дэд бүтэц, нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний цар хүрээ, орчны хяналт шинжилгээний цэгэн мэдээллийг тусгасан мета мэдээллийг цаасанд өнгө будаг, таних тэмдэгээр буулгасан хэлбэрээр болон файл хэлбэрээр тайланд хавсаргах.

1.9 Доорх хүснэгтийн мэдээллийг бүрэн тусгасан эсэхийг шалгах баганыг шинжээч бөглөнө.

д/д	Мэдээллийн төрөл	Мэдээллийг бүрэн тусгасан эсэхийг шалгах багана
5.1	Зурган мэдээлэлд тусгах мэдээлэл 1.4.11 Тосгон 1.4.12 Дэд бүтэц (зам, өндөр хүчдэл, цахилгаан сүлжээ, шугаман хоолой, станцын байршил, хашаа, тусгаарлагч, үерийн хамгаалалтын далан, аянга зайлуулагч гэх мэт) 1.4.13 Хог хаягдлын цэгийн байршил 1.4.14 Хог хаягдлын агуулахын байршил 1.4.15 Хог хаягдлын далан 1.4.16 Химийн бодисын агуулахын байршил 1.4.17 Орчны хяналт шинжилгээний дээж авах хяналтын цэгийн байршил 1.4.18 Тухайн жилд хуулах хөрс 1.4.19 Гадаад, дотоод овоолго 1.4.20 Техникийн нөхөн сэргээлтийн талбай 1.4.21 Биологийн нөхөн сэргээлтийн талбай 1.4.22 Гүний худгийн байршил 1.4.23 Дүйцүүлэн хамгааллын байршил	

Мэдээлэл үнэн зөвийг баталсан хүний гарын үсэг

/..... он .... сар .. өдөр /

**ЗУРГАА. ТУХАЙН ЖИЛИЙН АРГ АХЭМЖЭЭНЭЭС БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ХЯНАЛТЫН ХУУДАС**

1.10 Байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан нөлөөллийн дүн шинжилгээний хэсгээс доорх хүснэгтийн А, Б, В, Г дэхь багананд “тодорхойлсон”, “тодорхойлоогүй” “хамааралгүй” гэсэн 3 төрлийн хариултаас сонгож бөглөх.

1.11 Дүгнэлт гэсэн багана дахь дүгнэлтийг байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнийн нөлөөллийн дүн шинжилгээний хэсэгт Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны мэрэгжилтэн дүгнэлт гаргана.

Нөлөөллийн ангилал	А. Тооцсон эсэх	Б. Нөлөөллийн цар хүрээг тодорхойлсон эсэх	В. Нөлөөллийн эрчмийг тодорхойлсон эсэх	Г. Нөлөөллийн үргэлжлэх хугацааг тодорхойлсон эсэх	Дүгнэлт
6.1. Хөрсөнд үзүүлэх нөлөөлөл - Бохирдуулах - Эвдэх - Доройтуулах	Тодорхойлсон Тодорхойлсон Тодорхойлсон	Тодорхойлсон Тодорхойлсон Тодорхойлсон	Тодорхойлоогүй Тодорхойлоогүй Тодорхойлоогүй	Тодорхойлсон Тодорхойлсон Тодорхойлсон	
6.2. Гадаргын болон гүний усанд үзүүлэх нөлөөлөл - Бохирдуулах - Нөөцийг	Тодорхойлсон Тодорхойлсон	Тодорхойлсон Тодорхойлсон	Тодорхойлсон Тодорхойлсон	Тодорхойлсон Тодорхойлсон	
6.3. Амьтан, ургамалд үзүүлэх нөлөөлөл - амьдрах орчинг хуваах - амьдрах орчинг доройтуулах - амьдрах орчинг хомсдуулах - нөөцийг	Хамааралгүй Хамааралгүй Хамааралгүй Хамааралгүй	Хамааралгүй Хамааралгүй Хамааралгүй Хамааралгүй	Хамааралгүй Хамааралгүй Хамааралгүй Хамааралгүй	Хамааралгүй Хамааралгүй Хамааралгүй Хамааралгүй	
6.4. Агаарт үзүүлэх нөлөөлөл - Бохирдуулах - тоос	Тодорхойлсон Тодорхойлсон	Тодорхойлсон Тодорхойлсон	Тодорхойлсон Тодорхойлсон	Тодорхойлсон Тодорхойлсон	
6.5. Түүх соёлын дурсгалт эд зүйлс - Хамгаалах - Нүүлгэн	Тодорхойлсон Хамааралгүй	Тодорхойлсон Хамааралгүй	Тодорхойлсон Хамааралгүй	Тодорхойлсон Хамааралгүй	

Мэдээлэл үнэн зөвийг баталсан хүний гарын үсэг

/..... он .... сар .. өдөр /



## ДОЛОО. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ХЯНАЛТ

1.4.24 Төсөл хэрэгжүүлэгч нь доорх хүснэгтийн “А” багананд байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг тоогоор илэрхийлэх

1.4.25 Төсөл хэрэгжүүлэгч нь доорх хүснэгтийн “Б”, “В”, багананд байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хэмжих нэгжийг тогтоосон эсэхэд “тийм”, “үгүй” хариулт өгнө.

1.4.26 Доорх хүснэгтийн “Г” багананд байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хэмжих нэгжийг оновчтой тогтоосон эсэхэд Байгаль орчин, ногоон хөгжлийн мэргэжилтэнгүүд “хангалттай” “хангалтгүй” гэсэн дүгнэлт өгнө.

Тухайн жилийн байгаль хамгаалах арга хэмжээний чиглэл	А. Тоо	Б. Шалгуур үзүүлэлтийг тогтоосон эсэх	В. Шалгуур үзүүлэлтийн хэмжих нэгжийг тогтоосон эсэх	Г. Дүгнэлт
7.1. Нөлөөллөөс урьдчлан сэргийлэх зайлуулах арга		Тийм	Тийм	
7.2. Нөлөөллийг бууруулах арга хэмжээ		Тийм	Тийм	
7.3. Нөхөн сэргээлтийн арга хэмжээ 3.5 техникийн/ га эзэлхүүн 3.6 биологийн /га		Үгүй	Тийм	
7.4. Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээ		-	-	
7.5 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад		Тийм	Тийм	
7.6. Түүх соёлын дурсгалт эд зүйлийг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ		Үгүй	Үгүй	
7.7. Байгаль орчны менежментийн удирдлага зохион байгуулалтын арга		Тийм	Тийм	

Мэдээлэл үнэн зөвийг баталсан хүний гарын үсэг

/..... он .... сар .. өдөр /

### НАЙМ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЯНАЛТЫН ХУУДАС

Төсөл хэрэгжүүлэгч нь доорх хүснэгтийг “А, Б, В, Г” багананд байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг тоогоор илэрхийлэх

Хяналт шинжилгээний дээж	А. Дээж авах цэгийн тоо	Б. Дээж авах цэгийн байршил	В. Давтамж	Г. Төсөв Мян.төг
Хөрс	2	Карьерийн орчим	Жилд 1 удаа	70,0
Ус	1	Ундны ус авч хэрэглэж буй уст цэг	Жилд 1 удаа	70,0
Ургамал	-	Уурхайн дэвсгэр нутаг	-	-
Агаар	2	Ил уурхай, хөрсний овоолгын ойролцоо	Жилд 1 удаа	70,0